



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар

4/22

Модот

Ажлын хэсэг томилох тухай
(Хужхан, Согоот багуудын мал угаалгын
ванн шинээр барих, засварлах)

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн, 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, 50 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа Хужхан багт мал угаалгын ванн шинээр барих, Согоот багт мал угаалгын ванн засварлах ажлуудын гүйцэтгэх үйл ажиллагаанд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч	П.Ганчимэг	- Мал эмнэлгийн улсын байцаагч
Нарийн бичгийн дарга	С.Ган-Очир	- Нярав
Гишүүд	Б.Ганзориг	- I Багийн Засаг дарга
	Д.Мягмарсүрэн	- III Багийн Засаг дарга
	Ж.Тодбилэг	- Байгаль хамгаалагч

2. Дээрх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, байгуулсан гэрээний дагуу гэрээг дүгнэх, хүлээн авах акт үйлдэх, гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэгчээс гаргуулж авахыг ажлын хэсгийн ахлагч (П.Ганчимэг) –т үүрэг болгосугай.

ДАРГА

Ү.ИЧИНХОРЛОО

